

Аймгийн Засаг даргын 2020-оны ...  
дугаар сарын ...-ны өдрийн ...-и дугаар  
захирамжийн хавсралт

**ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАЖ, ДҮГНЭХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: -аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин,

аялал жуулчлалын газрын дарга

Нарийн бичгийн дарга: -аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин,

аялал жуулчлалын газрын уул уурхай, нөхөн сэргээлт, байгаль

орчны үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүдэд: -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,

хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн газар, байгаль

орчин, аялал жуулчлалын бодлого, төлөвлөлтийн асуудал

хариуцсан ахлах мэргэжилтэн

- Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч
- Онги-Таац голын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн
- Сумын байгаль орчны мэргэжилтэн
- Сумын байгаль хамгаалагч
- Тухайн багийн иргэдийн төлөөлөл

-оОо-



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 2/245

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн, аж ахуйн нэгжийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь шалгаж, дүгнэх ажлыг жил бүрийн 11 дүгээр сарын 30-ны дотор зохион байгуулж, дүгнэлт гаргаж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011100525

D:My Doc. Zahiramj. Zasag darga